

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

АГУУЛГА

1. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААН, ЗОРИЛГО, ХЭЛБЭР, ТӨРӨЛ.

- 1.1. Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
- 1.2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа.
 - 1.2.1. Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл.
 - 1.2.2. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл.
 - 1.2.3. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт.
 - 1.2.4. Нийгмийн даатгалын хамралт.
 - 1.2.5. Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж болон төлбөр, зардал.
 - 1.2.6. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд.
 - 1.2.7. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал.
 - 1.2.8. Мэдээлэл технологийн үйл ажиллагаа.
 - 1.2.9. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах.
 - 1.2.10. Хяналт шалгалт.
 - 1.2.11. Лавлах үйлчилгээ.
 - 1.2.12. Архив, албан хэрэг хөтлөлт.
- 1.3. Салбарын эрх зүйн орчин.
 - 1.3.1. Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.
 - 1.3.2. Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.
 - 1.3.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.
- 1.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.
- 1.5. Дотоод үйл ажиллагаа.
 - 1.5.1. Байгууллагын хүний нөөц.
 - 1.5.2. Байгууллагын санхүү төсвийн үйл ажиллагаа.

2. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ.

3. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
БХ	Байнгын Хороо
ЗГ	Засгийн газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НД	Нийгмийн даатгал
НДС	Нийгмийн даатгалын сан
НДҮЗ	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ЭМ	Эрүүл мэнд
ХХТАО	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ОХУ	Оросын Холбооны Улс

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны орлогын гүйцэтгэл

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны зарцуулсан хөрөнгө болон үйлчлүүлсэн хүний тоо

Хүснэгт 5. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 6. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 7. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 8. Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн байдал

Хүснэгт 9. Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудын бүтэц

Хүснэгт 10. НД-ын байгууллагын албан хаагчдын төрийн албан тушаалын ангилал, тоо

Хүснэгт 11. НД-ын байгууллагын албан хаагчдын боловсрол, мэргэжил

Хүснэгт 12. НД-ын байгууллагын албан хаагчдын нас, хүйсний мэдээлэл

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Нийгмийн даатгалын сангийн төсөв

График 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц

График 3. Нийгмийн даатгалын хамралт

График 4. Тэтгэвэр авагчдын бүтэц

График 5. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ

График 6. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

График 7. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт 1. Нийгмийн бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Байнгын хорооны хуралдаанаас өгөгдсөн чиглэлийг хэрэгжүүлсэн ажлын товч тайлан

Хавсралт 2. Нийгмийн даатгалын салбарын холбогдох эрх зүйн актын 2019 оны хэрэгжилтийн мэдээ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланд Хууль зүйн яам /хуучин нэрээр/-наас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийсэн болно.

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААН, ЗОРИЛГО, ХЭЛБЭР, ТӨРӨЛ.

Системчилсэн үнэлгээ хийх шалтгаан:

Тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө санхүү оновчтой болсон, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоох шаардлага гарсан.

Системчилсэн үнэлгээний зорилго:

Үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

Системчилсэн үнэлгээний хэлбэр:

Үнэлгээний хэлбэр нь хэрэгжсэн хөтөлбөр болон арга хэмжээнд өгөх хэрэгжилтийн үнэлгээ /ретроспектив/ болно.

Системчилсэн үнэлгээний зорилт:

Үнэлгээний зорилт нь байгууллагын дэвшүүлсэн зорилго, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, үр нөлөө болон тогтвортой байдлын уялдаа холбоо, хэрэгжилтийг тодорхойлж аль болох системтэй, объектив байдлаар төлөвлөсөн, хэрэгжиж буй болон хэрэгжсэн үйл ажиллагааг үнэлсэн болно.

Системчилсэн үнэлгээний төрөл:

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрсэнийг тодорхойлоход чиглэх бөгөөд Системчилсэн үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа.
- Салбарын эрх зүйн орчин.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.
- Дотоод үйл ажиллагаа.

1.1. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг.


НД – ын салбарын төв байгууллага болох НДЕГ нь Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлын хэрэгжилтийг зохион байгуулах, Нийгмийн даатгалын тухай багц хуулиудын төслийн санал, хэрэгжүүлэхтэй холбоотой журам, зөвлөмж, аргачлал, заавар боловсруулах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг хэтийн болон дунд хугацаанд төлөвлөх, хэтийн тооцоолол хийх, нийгмийн даатгалын сангийн болон салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилах, нийгмийн даатгалын сангийн төлөв байдалд судалгаа, дүгнэлт хийх, статистик үзүүлэлтүүд бэлтгэх, Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, шинээр байгуулах Хэлэлцээрийн төслийн санал боловсруулах, төв, орон нутгийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь Улсын Их Хурлаас томилогдсон Засгийн газар, Даатгуулагч, Ажил олгогчийг төлөөлсөн тус бүр 3, нийт 9 гишүүнтэй. Ажлын алба нь Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 12 орон тоотой ажиллаж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2018 оны А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 04 дүгээр тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар бүтэц, орон тоо, нэгжүүдийн чиг үүргийг 6 газар, 5 хэлтэстэй 82 хүний орон тоо, дэргэдээ 1 тасаг, 2 төв, 1 зөвлөл, 1 төв комисстойгоор шинэчлэн баталсны дагуу 2019 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Тамгын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү, бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар, Хуулийн хэлтэс, Үйл ажиллагааны хөгжлийн хэлтэс, Судалгааны хэлтэс, Хуримтлалын сан, өрийн удирдлагын хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс гэсэн нэгжүүдэд нийт 82 ажилтан, албан хаагчтай, дэргэдэх Мэдээллийн технологийн төв 9, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс 8, БНСУ дах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төвийн нийгмийн даатгалын тасаг 8 албан хаагчидтай ажилласан.

Мөн орон нутагт нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг хангах, чиг үүрэг бүхий Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын 31 газар, хэлтсүүдэд 1436 ажилтан албан хаагчид Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц



1.2. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.

НД – ын байгууллага нь нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, даатгуулагч, ажил олгогчдыг даатгалд хамруулан бүртгэх, шимтгэлийг орлогыг төвлөрүүлж санг бүрдүүлэх, даатгалын сангаас иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоон олгох, мэдээллийн цахим системийг хөгжүүлэх, даатгуулагч иргэдийн нийгмийн даатгалын талаархи хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг үндсэн үйл

ажиллагаагаа хэрэгжүүлэхээр 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт 100 арга хэмжээг тусгасан.

НД – ын байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний системчилсэн үнэлгээний дүнг харуулбал:

- Бүрэн хэрэгжсэн 84 арга хэмжээ.
- Хэрэгжих шатанд байгаа 13 арга хэмжээ.
- Хугацаа болоогүй хийгдэж байгаа 3 арга хэмжээ байгаа бөгөөд нийт хэрэгжилтийн хувь 93.81 хувь байна.


Нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 43 шийдвэрийн 96 заалт бүхий Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал гарсан. Дээрх тушаал шийдвэрийн 95 заалт буюу 98.9 хувь нь бүрэн хэрэгжиж биелэлтийн дүн 99.94 хувьтай үнэлэгдэв.

1.2.1. Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл.

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсөв.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогын хэмжээг 2,208.8 тэрбум төгрөг, үүнээс: нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1,603.3 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 605.5 тэрбум төгрөгөөр баталсан. Мөн хуулиар төсвийн нийт зарлагыг 2,068.5 тэрбум төгрөг, үүнээс: тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 2,043.7 тэрбум, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 24.8 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан.

График 1. Нийгмийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



1.2.2. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл.


Нийгмийн даатгалын сангийн орлого.

Нийгмийн даатгалын санд 2019 оны жилийн эцсийн байдлаар шимтгэлийн орлого 1,603.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,879.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж,

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

орлогын төлөвлөгөөг 117.2 хувиар биелүүлсэн. /энэ дүнд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 605.5 тэрбум төгрөг ороогүй/

График 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц /хувиар/



Нийгмийн даатгалын сангийн нийт орлогын 40.1 хувь буюу 996.1 тэрбум төгрөгийг ажил олгогч, 31.9 хувь буюу 792.7 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 3.7 хувь буюу 90.7 тэрбум төгрөгийг сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулсан мөнгөн хадгаламжийн болон ҮОМШӨ-ний даатгалын сангаас төлсөн шимтгэл, бусад орлогоор тус тус бүрдүүлсэн.

Мөн орлогын 24.4 хувийг /605.5 тэрбум төгрөг/ тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс авсан дэмжлэг эзэлж байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт /тэрбум төгрөг/

№	Орлогын төрөл	2018	2019	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1	Улсын төсвөөс олгох дэмжлэг	609.8	605.5	-4.3	0.71%
2	Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас	639.5	775.8	136.3	17.6%
3	Төсөвт газраас	149.7	220.3	70.6	32%
4	Даатгуулагчаас	541.4	701.2	159.8	22.7%
5	Сайн дурын даатгуулагчаас	69.2	88.4	19.2	21.7%
6	Гадаадад ажиллаж буй иргэдийн	3.0	3.0	-	-
7	ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн	0.8	1.2	0.4	33.3%
8	Бусад орлого	76.4	89.6	13.2	14.7%
Нийт		2,089.8	2,485.0	395.2	141.3%

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оноос 395.2 тэрбум төгрөгөөр буюу 18.9 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны орлогын гүйцэтгэл

№	Орлого	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт орлогод эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	2,075.0	83.5
2	Тэтгэмжийн даатгалын сан	157.5	6.3
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	211.0	8.5
4	Ажилгүйдлийн даатгалын сан	41.5	1.7
Нийт		2,485.0	100.0

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Нийт сангийн орлогын 83.5 хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байгаа бол ажилгүйдлийн даатгалын сан 1.7 хувийг эзэлж байна.

Жилийн эцсийн байдлаар арилжааны 10 банкинд нийт 484.2 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжийг 7-15 хувийн хүүтэй байршуулж, 67.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.

1.2.3. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт.

Нийгмийн даатгалын сангийн зардлын төсөв 2,068.5 тэрбум төгрөг бөгөөд 2,062.2 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд олгосон.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны зарлагын гүйцэтгэл

№	Зардал	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт зардалд эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	1,839.2	89.2
2	Тэтгэмжийн даатгалын сан	124.1	6.0
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	30.8	1.5
4	Ажилгүйдлийн даатгалын сан	43.6	2.1
5	Үйл ажиллагааны зардал	24.5	1.2
Нийт		2,062.2	100.0

Нийт сангийн зардлын 89.2 хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байгаа бол ҮОМШӨ-ний даатгалын сан 1.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны зарцуулсан хөрөнгө болон үйлчлүүлсэн хүний тоо

№	Нийгмийн даатгалын сан	2017 он		2018 он		2019 он	
		Хүний тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Хүний тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/	Хүний тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум. төг/
1	Тэтгэврийн	388.6	1,417.4	398.1	1,619.3	412.9	1,839.2
2	Тэтгэмжийн	194.4	100.2	209.6	112.1	210.3	124.1
3	ҮОМШӨ-ний	9.6	29.4	9.4	29.9	8.7	30.8
4	Ажилгүйдлийн	21.1	34.6	21.4	34.3	23.1	43.6
5	Үйл ажиллагааны зардал		21.2		18.9		24.5
Нийт		613.7	1,602.8	638.5	1,814.5	655.0	2,062.2


Нийгмийн даатгалын сангаар үйлчлүүлсэн иргэдийн тоо 17.7 мянга буюу 2.8 хувиар, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 247.7 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар тус тус өссөн бөгөөд НД – ын байгууллагын үйл ажиллагааны зардалд 24.5 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 29.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.2.4. Нийгмийн даатгалын хамралт.

Нийгмийн даатгалын мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар 48.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн нь 2018 онтой харьцуулахад 2.4 мянган ажил олгогч буюу 5.2 хувиар нэмэгдсэн.

Мөн албан журмын болон сайн дурын даатгалд бүгд 1,157.2 мянган даатгуулагч хамрагдсан нь Үндэсний статистикийн хорооноос 2019 онд гаргасан нийт ажиллах хүчний /1,293.6 мянган хүн/ 89.5 хувийг эзэлж байна

График 3. Нийгмийн даатгалын хамралт /мян.хүн/



1.2.5. Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж болон төлбөр, зардал.

Тэтгэврийн даатгалын сан

Тайлант жилд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, цэргийн албан хаагчийн тэтгэвэр авч байгаа 412.9 мянган хүнд 1.8 их наяд төгрөг зарцуулсан.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 55.5 мянган тэтгэвэр авагч, 18.6 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 355.8 тэрбум төгрөг зарцуулсан.

Хүснэгт 5. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тэтгэврийн төрөл	2017 он		2018 он		2019 он	
		Тэтгэвэр авагчдын тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/	Тэтгэвэр авагчдын тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/	Тэтгэвэр авагчдын тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/
1	Өндөр насны	282.6	1,065.6	293.7	1,222.5	307.5	1,396.9
2	Тахир дутуугийн	67.9	185.1	66.3	208.2	67.0	230.9
3	Тэжээгчээ алдсаны	20.8	58.8	20.2	64.1	19.8	70.1
4	Цэргийн	17.4	106.3	17.8	122.8	18.6	139.4
Нийт		388.6	1 415.8*	398.1	1 617.6*	412.9	1 837.3*

* Бусад зардал ороогүй болно.

График 4. Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/

Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 7.3 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 92.7 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.

2019 оны байдлаар нийгмийн даатгалын сангаас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 310.0 мянган төгрөг байгаа нь амьжиргааны доод түвшингээс 42.3 хувиар илүү байна. Нийгмийн даатгалын сангаас нийтдээ 412.9 орчим мянган тэтгэвэр авагчдад 1,837.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.



График 5. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ /мянган төгрөг/



Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 8.9 хувиар өссөн.

Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас 210.3 мянган даатгуулагчдад 124.0 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ.

Хүснэгт 6. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тэтгэмжийн Төрөл	2017 он		2018 он		2019 он	
		Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	123.4	16.2	133.9	17.9	132.9	19.8
2	Жирэмсний болон амаржсаны	57.8	70.6	61.5	79.9	63.4	90.2
3	Оршуулгын	13.2	13.3	14.1	14.1	13.9	13.9
Нийт		194.4	100.1*	209.5	111.9*	210.3	124.0*

* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сан

2019 оны жилийн эцсийн байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 4.5 мянган тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 27.0 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1.1 мянган иргэний тэтгэмжид 0.7 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд 0.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 7. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	2017 он		2018 он		2019 он	
		Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум. төг/
1	Тахир дутуугийн тэтгэвэр	4.3	23.6	4.3	23.9	4.0	24.2
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.6	2.5	0.6	2.6	0.5	2.7
3	ХЧТА-ны тэтгэмж	1.1	0.6	1.1	0.7	1.1	0.7
4	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.02	0.02	0.02	0.02	0.02	0.02
5	Рашаан сувиллын зардал	3.6	1.0	3.4	0.9	3.2	0.9
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	0.7	-	0.8	-	1.0
7	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл	-	0.9	-	0.9	-	1.2
Нийт		9.6	29.3*	9.4	29.9*	8.8	30.8*

* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

Сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ажилгүйдлийн даатгалын сан

2019 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 23.1 мянган даатгуулагч 43.5 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 7.9 хувиар, зарлагын хэмжээ 26.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

График 6. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө



1.2.6. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хөгжүүлэлт, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2019 оныг “Танд ойрхон-найрсаг үйлчилгээний жил” болгон зарлаж, иргэд даатгуулагчид, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай, ээлтэй хүргэх, сурталчлах, нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар хүргэх ажлыг өргөжүүлж, тэдний нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтыг дээшлүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж ажиллалаа.

Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, үйлчилгээний стандарт, журмыг мөрдүүлэх хүрээнд улсын байцаагч, ажилтнуудын үйлчлүүлэгчтэй харилцах журам, ажлын байрны стандартыг тогтоосон “Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний гарын авлага”-ыг боловсруулан гаргаж, нэвтрүүлсэн.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд явуулын үйлчилгээг 43 удаа зохион байгуулж 13770 иргэнд хүрч үйлчлэн, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

2019 оны 12 сарын байдлаар нийт 273 иргэний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гэрлэлт, гэрлэлт цуцалсан зэрэг мэдээллийг төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны “ХУР” системээс хурууны хээгээр нь шалган авч ашигласан байна.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болзол нь ойртсон даатгуулагч хуульд заасан болзол, нөхцөл, баримт бичгийн бүрдлийн шаардлага хангаж байгаа эсэхээ нийгмийн даатгалын байгууллагын вэб хуудсаар орж, урьдчилан тооцоолох, шалгуулах, зөвлөгөө мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлсэн “Өндөр насны тэтгэвэр тооцоолох” вэб програмыг хөгжүүллээ.

Иргэд, даатгуулагчдын регистрийн дугаараар нь ургийн овог, эцгийн болон өөрийн нэр, хүйс, төрсөн огноо, оршин суугаа хаягийн мэдээлэл, мөн нас барсан

эсэхийг улсын бүртгэлийн мэдээллийн сангаас харах зориулалт бүхий вэб програм хангамжийг шинээр боловсруулж төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудад нэвтрүүлээ.

2019 оны байдлаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс хооронд 4507 шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцож, 17809 иргэд даатгуулагчид лавлагаа авах хүсэлт өгснөөс нийт давхардсан тоогоор 29289 шимтгэл төлөлтийн лавлагааг олгосон байна.

1.2.7. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал.

Улсын хэмжээнд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор тогтоогдсон хөдөлмөрийн чадвараа алдсан 111 386 иргэн байгаагаас нийгмийн даатгалын сангаас 71 722 иргэн, нийгмийн халамжийн сангаас 39 664 иргэн тэтгэвэр, тэтгэмж авч байна.

Мөн 2019 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 10 811, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулсан 89 441, цуцлуулсан 8 599, нас барсан 2 535, хөдөлмөрийн нөхцөл сольсон 82, ажлын цаг хорогдуулсан 14 даатгуулагч байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөговь, Дорнод, Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст дахин магадлалыг зохион байгуулж, нийт 1598 даатгуулагчийн тахир дутуугийн хувийн хэргийг шалгаж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 86 даатгуулагчийг дахин магадлалд хамруулж, 3 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж шийдвэрлэв. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгийн нийт 50 гаруй эмч, мэргэжилтнүүдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Түүнчлэн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос Төв, Дорноговь аймгуудад бүрдмэл магадлалыг зохион байгуулж, нийт 1335 иргэдийг хамруулав. Үүнд: 1134 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр, 34 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 93 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг нэмж, 45 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг бууруулж, 102 иргэний заалт, оношийг тус тус өөрчилж магадлав.

1.2.8. Мэдээлэл, технологийн үйл ажиллагаа.

Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, “Даатгуулагчийн бүртгэл вэб програм хангамж” болон Төрийн үйлчилгээний 109 цахим машин гэсэн 3 цахим сувгаар шаардлагатай мэдээллүүдийг нь цаг тухай бүр түргэн шуурхай хүргэх ажил тогтмол хийгдэж байна. Тухайлбал:

1. Иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээний 4 төрлийн томоохон мэдээллийг гар утсаараа харах “Нийгмийн даатгал” аппликейшийг одоогийн байдлаар 133.1 мянган даатгуулагч гар утсандаа суулгаж, 81.2 мянган

- даатгуулагч эрхээ баталгаажуулан идэвхтэй ашиглаж байна. Эдгээрээс 0.9 мянган хэрэглэгч онлайнар эрхээ баталгаажуулжээ.
- Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний 4 төрлийн томоохон мэдээллийг интернэт сувгаар хүргэх ажил амжилттай хэрэгжиж, одоогийн байдлаар 31.9 мянган даатгуулагч интернэтээс QR кодтой “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт”-оо хэвлэн авсан байна. Мөн иргэд даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллээ цахимаар харах ажил тогтмол явагдаж байгаа бөгөөд 4.0 мянга гаруй иргэний өргөдөл цахим мэдээлэлд бүртгэгдэж, 2.0 гаруй мянган даатгуулагчийн өргөдөл шийдвэрлэгдсэн мэдээлэл иргэнд мессежээр илгээгдсэн байна.
 - Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчид төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаар олгож буй 4 төрлийн лавлагаа тодорхойлолтыг өгөх ажил тогтмол хийгдэж, одоогийн байдлаар нийтдээ 484.4 мянган лавлагаа, тодорхойлолтыг ТҮЦ машинаас хэвлэн авсан байна.
 - Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглагдаж буй нийт 60 гаруй програм хангамжуудад Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, НДҮЗ, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан хууль, тогтоомж, аргачлал, зааварчилгаа болон хэрэглэгчийн хүсэлтийн дагуу нийтдээ 80 гаруй өөрчлөлт, хөгжүүлэлт хийж, 6 систем шинээр нэвтрүүлж, төв орон нутгийн байгууллагуудад ашиглах боломжийг бүрдүүллээ.

1.2.9. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах.

Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны талаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах чиглэлээр анхаарч ажилласан. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн 96 байгууллагатай хамтран ажиллаж, нийт 1183 удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл, ярилцлага, нийтлэлийг тархаасан.
- Нээлттэй хаалганы өдөрлөгийг улсын хэмжээнд хоёр удаа зохион байгуулж нийт 20 497 иргэнд нийгмийн даатгалтай холбоотой хууль тогтоомжийн зөвлөгөө мэдээлэл өгч, 13 466 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Тодруулбал 721 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулж, 1 213 даатгуулагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлж, 2 943 иргэний дэвтрийг баталгаажуулж, 1 190 иргэн гар утасны аппликэйшний бүртгэлээ баталгаажуулав.
- Салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг 644 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 13 231 байцаагч, ажилтан хамрагдсан.
- Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 2400 удаагийн сургалтад 235 016 хүнийг хамруулсан байна.

1.2.10. Хяналт шалгалт.

Тэтгэмжийн даатгалын болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон тэтгэмжийн тогтоолт, олголт, сангийн төлөвлөлт,

гүйцэтгэлийн үндэслэлийг шалгах шалгалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, мэдээллийн нэгдсэн сангаас зөрчилтэй байх магадлалтай 75 534, хяналт шалгалтын программаар зөрчилтэй байх магадлалтай 40 521, давхардсан тоогоор нийт 116 055 даатгуулагчдын мэдээллийг шалгав. 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 419 иргэнд олгосон нийт 115.7 сая төгрөгийн төлбөр зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоон 67.1 сая төгрөгийг барагдуулж 48.5 сая төгрөгийн үлдэгдэл буюу 72.2 хувийг барагдуулаад байна.

Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудийн хэрэгжилтийг шалгаж, даатгуулагчид олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл тооцож төлөөгүй мөн дутуу тооцож төлсөн 1 иргэн, 45 байгууллагын зөрчил илрүүлж, 10 аж ахуйн нэгжийг 30.0 сая төгрөгөөр торгов.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт бүртгэлтэй гадаадаас ажиллах хүч авч ажиллуулдаг нийт 1188 аж ахуйн нэгжид Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд шалгалт хийж, нийт 193 байгууллагын 2 647 даатгуулагчид олгосон 4.9 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл тооцож, нийгмийн даатгалын санд төлөөгүй зөрчил илрүүлж, 979.6 сая төгрөгийн шимтгэл, 477.6 сая төгрөгийн алданги нийт 1,457.2 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэхээр Улсын байцаагчийн акт тогтоож актыг 100 хувь барагдуулсан.

Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэгч 81 аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгахад 42 аж ахуйн нэгж байгууллага нь зөрчилгүй дүгнэгдэж, 39 аж ахуйн нэгж, байгууллага буюу 48.1 хувь нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4, 15, 16, 17 дугаар зүйлийг тус тус зөрчиж нийт 4 957 даатгуулагчид олгосон 4.5 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцож төлсөн зөрчил илрүүлж, 987.8 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн ногдуулж 493.9 сая төгрөгийн алданги тооцон нийт 1481.8 сая төгрөгийн төлбөрийг нийгмийн даатгалын санд төлүүлэхээр Улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэлээ. Одоогоор актын барагдуулалт 90.0 орчим хувьтай байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг Дорнод, Хөвсгөл, Баян-Өлгий, Дорноговь, Орхон аймгуудийн нийгмийн даатгалын хэлтэст шалгаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүллээ. Шалгалтаар дээрх 5 аймгийн 2015-2018 онуудад шинээр тогтоогдсон нийт 14608 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэг, 10512 даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэг, хамрагдан шалагагдлаа. Шалгалтаар нийт 81 тэтгэвэр авагчид илүү болон дутуу тооцож олгосон 74.9 сая төгрөгийн, 14 даатгуулагчийн ажилгүйдлын даатгалын сангаас тэтгэмж авч байх хугацаандаа шүүхийн шийдвэрээр ажилдаа томилогдож цалин, тэтгэмжийг давхардуулан авсан 14 даатгуулагчийн 21.7 сая төгрөгийн нийт 95 даатгуулагчтай холбоотой 96.6 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлэн Улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж шалгалтын хугацаанд нийт

93.4 сая төгрөг буюу 90.4 хувийг барагдуулж ажиллаа. Мөн 120 хоногоос дээш насжилттай 414.0 сая төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулж ажилласан.

Хүснэгт 8. Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн байдал

№	Аймаг, дүүргийн нэр	Тэтгэврийн даатгалын сан /илүү -дүтүү/	Тэтгэмжийн даатгалын сан /илүү -дүтүү/	Ажилгүйдлийн даатгалын сан /илүү -дүтүү/	Төлбөр, зөрчлийн дүн /сая.төг/	Барагдуулалт	Үлдэгдэл	Хувь
1	Дорнод	5.8	-	4.5	10.3	6.9	3.4	66.6
2	Хөвсгөл	45.7	-	3.1	48.8	16.7	32.1	34.2
3	Баян-Өлгий	4.8	-	6.3	11.2	7.8	3.4	70.2
4	Дорноговь	10.8	-	4.4	15.2	9.5	5.7	62.5
5	Орхон	9.7	-	7.1	16.8	9.7	7.1	58.0
	Аймгийн дүн	76.8	-	25.4	102.3	50.6	51.7	-
6	Аж ахуйн нэгж байгууллага	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос НДШ төлөөгүй зөрчилд			4.3	4.3	-	100
	Нийт төлбөр зөрчлийн дүн				106.6	54.9	51.7	51.5

2.1.11. Лавлах үйлчилгээ.

Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний чанар, ажилтнуудын харилцааны талаарх мэдээллийг 7777-1289 утсаар хүлээн авч байгаа бөгөөд 2019 онд нийт 280 225 дуудлаганд хариу өгч ажилласан.

Хариу өгсөн дуудлагыг агуулгаар нь задалбал:

- Тэтгэврийн даатгалын тухай-10% - 28 304
- Сайн дурын даатгалын талаар –19% - 53 779
- Шинэ хуулийн талаар - 5% - 14 153
- Тэтгэмжийн даатгалын тухай – 35% - 99 066
- Ажил олгогчын шимтгэл төлөлт – 15% - 42 457
- Харьяа дүүргийн байршил, холбоо барих утас данс – 5% - 14 153
- Шимтгэлийн хувь хэмжээ – 10% - 28 304
- Санал гомдол – 1% - 9 ирсэн бөгөөд хариуг шуурхай өгч ажиллалаа.

2.1.12. Архив, албан хэрэг хөтлөлт.

Нийгмийн даатгалын албан хэрэг хөтлөлт архивын ажлыг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Баримт бичгийн улсын стандарт”, “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын дагуу хөтлөн явуулсан. Ерөнхий газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 8653 бичгийн эргэлттэй байснаас ирсэн албан бичиг 3541, гадагш явуулсан албан бичиг 3517, иргэд, хуулийн этгээдийн 595 өргөдөл, гомдол бүртгэгдэж, 589 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн.

Архивын ерөнхий газар, Төрийн албаны зөвлөлтэй хамтарсан 4 жил тутамд зохион байгуулдаг "Улсын үзлэг"-т байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал зэрэг үзүүлэлтүүдээр ажлаа дүгнүүлж 92 буюу "А" үнэлгээ авч ажиллажээ.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2019 оны Жилийн эцсийн байдлаар иргэдээс 595 өргөдөл ирүүлсэн бөгөөд энэ нь өмнөх онтой /634/ харьцуулахад 6.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өргөдөл, гомдлын 589 буюу 98,9 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн, бөгөөд нийт 100 гаруй иргэнд мэргэжлийн зөвлөгөө, тодруулга, мэдээллийг утсаар болон биечлэн уулзаж өгсөн байна.

Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудийн хэрэгжилтийг шалгаж, даатгуулагчид олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл тооцож төлөөгүй мөн дутуу тооцож төлсөн 1 иргэн, 45 байгууллагын зөрчил илрүүлж, 10 аж ахуйн нэгжийг 30.0 сая төгрөгөөр торгов.

1.3. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.

1.3.1. Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.

➤ Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалыг батлуулсан.

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын 2018 оны А/73 дугаар тушаалын дагуу холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулсан Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсэг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудын төслийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулсан.

➤ Тэтгэврийн параметрийг өөрчилсөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэврийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлсэн, 20 жил 6 сараас дээш хугацаанд шимтгэл төлсөн бол 60/55 насандаа тэтгэвэр тогтоолгох зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулснаар дээрх нөхцөлөөр 2,8 мянган иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон.

➤ Шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн.

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар ажил олгогчийн

болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2018 онд 1.0, 2019 онд 0.5 пунктээр тус тус нэмэгдүүлэн 8.5 хувь болгон өөрчилсөн. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд энэ хуулийг хэрэгжүүлж ажилласнаар 2019 оны байдлаар тэтгэврийн даатгалын санд 1,666.7 тэрбум төгрөг хуримтлуулсан бөгөөд энэ нь 2018 онтой харьцуулахад 527.5 тэрбум төгрөгөөр өссөн.

1.3.2. Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.

➤ **Тэтгэврийн хэмжээг 8 орчим хувиар нэмэгдүүлж, дундаж тэтгэврийг 379.8 мянган төгрөгт хүргэв.**

Засгийн газрын 2019 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 26 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 24.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 310.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 270.0 мянган төгрөг болов. Тэтгэврийн нэмэгдэлд 119.5 тэрбум төгрөгийг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 379.8 мянган төгрөгт хүрэв.

➤ **Тэтгэврийн зээлийн хүүг дахин бууруулав.**

Тэтгэвэр олгодог арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2019 оны 01 дүгээр сард 12 хүртэлх сарын тэтгэврийн 70 хувьтай тэнцэх хэмжээний зээлийн хүүг 2-8 пунктээр бууруулан сарын 0.8 хувь, жилийн 10 хувь болгосон ба Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 06 дугаар тогтоолын дагуу 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тэтгэвэр барьцаалсан зээлийн дээд хугацааг 24 сар болгон, 12 сар хүртлэх хугацаатай зээлийг жилийн 10 хувиар олгох ажлыг үргэлжлүүлэн, 13-24 сарын хугацаагаар олгох зээлийн хүүг 2.4 пунктээр бууруулан жилийн 15.6 хувь болголоо. Ингэснээр 223235 тэтгэвэр авагч 320.3 тэрбум төгрөгийн зээлийг дээрх буурсан хүүгээр авч, нийтдээ 5.7 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна.

➤ **Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан шийдвэрийг хэрэгжүүлж байна.**

Малчдын өндөр насны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан хуулийн хэрэгжилтийг зохион байгуулснаар 9.4 мянган малчинд тэтгэвэр тогтоож, тэтгэвэрт 30.3 тэрбум төгрөг зарцуулав. Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”, “Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам”-ын дагуу 337 сум, 9 дүүрэгт зөвлөл байгуулагдан ажиллаж, 2.6 мянган малчин жил тодорхойлуулах хүсэлт гаргаснаас 2.2 мянган иргэний малчнаар ажилласан хугацааг тодорхойлж, эдгээр малчинд өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөл бүрдсэн.

1.3.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь 2019 онд 8 удаа хуралдаж, 22 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 13 тогтоол шийдвэрийг баталж гаргасан.

➤ **Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журмыг шинэчлэн гаргасан.**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсийг Үндэсний статистикийн хороотой ижил аргачлалаар буюу нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дундаж хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалд шимтгэл төлдөггүй цэргийн байгууллагын ажиллагчдын хөдөлмөрийн хөлс болон сайн дурын даатгуулагчдын хөдөлмөрийн хөлсийг оруулахгүйгээр тооцдог байхаар журамлаж, “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журам”-ыг шинэчлэн гаргалаа.

➤ **Мөнгөн хадгаламжийн гэрээний загварт нэмэлт, өөрчлөлт оруулсан.**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 03, 08 дугаар тогтоолуудаар Үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар”-т гэрээг цуцалсан болон үргэлжлүүлэн сунгагдаагүй бол хадгалагч нь мөнгөн хөрөнгийг нийгмийн даатгалын санд шууд шилжүүлэх, тэтгэврийн зээл олгоход зориулж тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилгоор эх үүсвэр болгон байршуулж буй мөнгөн хадгаламжийн хүүний талаар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөнгөн хадгаламж байршиж байгаа 9 арилжааны банктай байгуулсан 37 гэрээнд 2019 оны 05 дугаар сарын 15-21-ны хооронд өөрчлөлт оруулж баталгаажууллаа. Мөн тогтоол батлагдсанаас хойш хугацаанд хийсэн 12 “Мөнгөн хадгаламжийн гэрээ”-нд дээрх заалтыг оруулан байгуулж, 0.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлого сангийн харилцах дансуудад нэмж төвлөрүүллээ. Мөн 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс хойш хугацаанд тэтгэврийн зээлийн хүү бууруулах зорилгоор арилжааны 7 банктай шинээр байгуулсан “Мөнгөн хадгаламжийн гэрээ”-нд холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусган, мөрдөн ажиллаж байна.

➤ **Капитал банкинд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан авахаар ажиллаж байна.**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 04 дүгээр тогтоолоор татан буугдсан Капитал банкинд байршуулсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг тооцоо нийлэн баталгаажуулах, төлбөрийг нэхэмжлэх, нийгмийн даатгалын санд буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг сар тутам Үндэсний зөвлөлд мэдээлж байхыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосон. Тогтоолын дагуу Капитал банкны эрх хүлээн авагчтай нийт 124 харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл, хүүгийн тооцооллыг хийж, тооцоо нийлэн нэхэмжлэх дүнг 104.15 тэрбум төгрөгөөр баталгаажуулж, уг хөрөнгийг

“Даатгагдаагүй хадгаламжийн төлбөр”-т хамааруулах талаар Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаад байна.

➤ **Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан.**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор Сангийн сайдын 2019 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 79, 118 дугаар тушаалыг тус тус үндэслэн нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуулиар тогтоосон хугацаанд нь олгох, шимтгэлийн авлагыг бууруулах, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн сахилгыг ханган ажиллах чиглэлээр нийгмийн даатгалын сангийн болон аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн төсвийн 2019 оны хуваарьт холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, батлан мөрдүүлэв.

➤ **24 сарын хугацаатай олгогддог зээлийн хүүг бууруулсан.**

Тэтгэвэр олгодог арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 06 дугаар тогтоолыг үндэслэн 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тэтгэвэр барьцаалсан зээлийн дээд хугацааг 24 сар болгон, 12 сар хүртлэх хугацаатай зээлийг жилийн 10 хувиар олгох ажлыг үргэлжлүүлэн, 13-24 сарын хугацаагаар олгох зээлийн хүүг 2.4 пунктээр бууруулан жилийн 15.6 хувь болгосноор 21124 тэтгэвэр авагч 103.2 тэрбум төгрөгийн зээлийг авч, тэтгэвэр авагчид 0.7 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна.

➤ **Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг хэвээр мөрдөв.**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 13 дугаар тогтоолоор баталсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн 1 жилийн хүүгийн хэмжээг Монголбанкны бодлогын хүү болон эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан 14.0 хувиас багагүй байхаар тогтоосныг хэвээр мөрдсөн. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны “Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг батлах тухай” 09 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт 2019 оны 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт заалтын дагуу 2019 онд тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилгоор арилжааны 8 банктай 117.4 тэрбум төгрөгийн хадгаламжийг 12.6 хувийн хүүтэй, 110.8 тэрбум төгрөгийн хадгаламжийг 7.0 хувийн хүүтэй, нийт 228.2 тэрбум төгрөгийн хадгаламж байршуулаад байна.

➤ **Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад байршуулах дээд хэмжээг 760.0 тэрбум төгрөгөөр тогтоосон.**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д “Хуримтлалын сангаас арилжааны банкинд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл хамтран тогтооно” гэсэн заалтыг хэрэгжүүлэх

зорилгоор 2019 онд арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 760.0 тэрбум төгрөгөөр тогтоосон.

➤ **Даатгуулагчдын нэрийн дансны 2018, 2019 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоолоо.**

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасны дагуу Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 11 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн 2015-2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үндэслэн зөвхөн албан журмын даатгуулагчдын шимтгэл төлсөн бодит дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтийн хувиар тооцон, Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн саналын дагуу даатгуулагчдын нэрийн дансны 2018 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 4.8, 2019 оных 7.8 хувиар тус тус тогтоолоо.

➤ **Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тогтоолоо.**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар тогтоолоор Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу Үндэсний статистикийн газраас гаргасан тооцоо, саналыг үндэслэн тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг 2020, 2021 онд 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрэгтэй даатгуулагч 15 жил 6 сар, 2019, 2020, 2021 онд 55 нас хүрч өндөр насны тэтгэвэр тогтоолгох эмэгтэй даатгуулагч 22 жил 6 сар байхаар тус тус тогтоолоо.

1.4. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.

Монгол улсаас нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Турк, Польш, Чех Улсуудтай байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах, ОХУ-тай хэлэлцээрийг шинэчлэх болон Казахстан Улстай шинээр байгуулахаар ажиллаж байна. Эдгээр хэлэлцээрээр даатгуулагчид харилцан төлсөн шимтгэлдээ ногдох тэтгэврийг тэдгээр улсын ижил төрлийн сангаас авах боломж бүрдэх бөгөөд өндөр насны тэтгэврээс гадна ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж авах эрх хоёр талдаа харилцан үүсэх ач холбогдолтой юм.

Монгол улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын алба хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж, тус улсын тэтгэврийн даатгалд хамрагдан шимтгэл төлж байсан иргэдийн шимтгэлийн мөнгийг буцаан олгуулах ажлыг гүйцэтгэж байна.

БНСУ-д гэрээгээр ажиллах иргэдэд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалтыг лхагва гараг бүр Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий газартай хамтран зохион байгуулж, 2019 оны 12 сарын 31-ний байдлаар 557 иргэнтэй гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэсэн.

Тайлангийн хугацаанд 1641 даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулсан бол 623 даатгуулагч нийгмийн даатгалын дэвтрээ буцаан авч, 270 даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээсэн байна.

Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 2019 онд 77 иргэн 177.1 сая вонн нэхэмжилж, 66 иргэний 152.3 сая вонны шимтгэлээ буцаан авчээ.

1.5. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА.

1.5.1. Байгууллагын хүний нөөц.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/22 дугаар тушаалаар нийгмийн даатгалын салбарын бүтэц орон тоог шинэчлэн тогтоосон бөгөөд одоо салбарын хэмжээнд 1436 ажилтан, албан хаагч ажиллаж байна.

Хүснэгт 9. НД-ын салбарын ажилтнуудын бүтэц

№	Албан тушаалын ангилал	Тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	42	2.9
2	Гүйцэтгэх албан тушаалтан	1233	85.7
3	Үйлчилгээний	93	6.6
4	Гэрээт ажилтан	68	4.8
Нийт		1436	100

Нийгмийн даатгалын байгууллага нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 78 бүлгээр 100 ажил хийж гүйцэтгэхээр боловсруулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож, нийт 1436 ажилтан, албан хаагчтайгаар ажил үүргээ гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 10. НД-ын байгууллагын албан хаагчдын төрийн албан тушаалын ангилал, тоо

№	Төрийн албан тушаалын ангилал	Тоо
1	Жинхэнэ албан хаагч	1348
2	Төрийн үйлчилгээний албан хаагч	69
3	Гэрээт ажилтан	114
4	Үүнээс: Улсын байцаагч	852

Хүснэгт 11. НД-ын байгууллагын албан хаагчдын боловсрол, мэргэжил

№	Боловсрол			
	Боловсролын зэрэг	Тоо	Мэргэжил	Тоо
1	Доктор	2	Санхүүч, Эдийн засагч, Нягтлан бодогч	973
2	Магистр	103	Эрх зүйч	85
3	Бакалавр	1251	Бусад мэргэжил	293
4	Бүрэн дунд	70	-	-
5	Тусгай дунд	10	-	-

Хүснэгт 12. НД-ын байгууллагын албан хаагчдын нас, хүйсний мэдээлэл

№	Нас	Тоо	Хүйс	Тоо
1	30 хүртэлх	301	Эрэгтэй	397
2	31-40	785	Эмэгтэй	1039
3	41-50	276	-	-
4	51-60	74	-	-

Тайлант хугацаанд шинээр томилогдсон албан хаагчдад “Шинэ ажилтнуудын сургалт”-ыг зохион байгуулж, Төрийн албаны хууль тогтоомж, архив албан хэрэг хөтлөлт, Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, байгууллагын дотоод мэдээлэл, нууцлалын баримт бичигтэй ажиллах талаар мэдээлэл хүргэж ажилласан.

Мөн төрийн албаны тухай хуулинд нийцүүлэн нийгмийн даатгалын байгууллагын нийт албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх, Able программд албан хаагчдын хувийн мэдээллийг оруулах, бүх газар, нэгжийн албан тушаал тус бүрээр “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулах, Хүний нөөцийн чиглэлийн 6 судалгааг шинэчлэх ажлууд хийгдсэн.


Ажилтнуудын зэрэг дэвийн судалгааг шинэчлэн гаргаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/381 дүгээр тушаалаар ажилтнуудад зэрэг дэвийн нэмэгдэл олгож ажилласан.

Ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд “Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган албан хаагчдын мэдлэг, мэдээлэл олгох сургалт хийх, буцалтгүй тусламж, тэтгэмж, хөнгөлөлтөнд хамруулах ажлууд хийгдсэн байна.

1.5.2. Байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын байгууллагын 2019 оны үйл ажиллагааны зардалд 24.8 тэрбум төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 24.5 тэрбум төгрөгийг зарцуулж 0.3 тэрбум төгрөгийг хэмнэсэн. Энэхүү хэмнэлт нь төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, хэмнэлтийн горимоор ажилласантай холбоотой. Нийт урсгал зардлын 76.4 хувь буюу 18.7 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын салбарын 1.4 мянган ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан.

График 7. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал /тэрбум төгрөг/



ХОЁР. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь системчилсэн үнэлгээнд хамрагдах хугацаанд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2022 он)-ийг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд 2019 оныг “Танд ойрхон-найрсаг үйлчилгээний жил” болгон зарлаж, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, биелэлтийг тайлагнаж ажиллсан байна.

➤ **Шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн хуулийн зохицуулалт хэрэгжиж эхэллээ.**

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тус тус 0.5 пунктээр нэмэгдүүлэн 8.5 хувь болгон өөрчилсөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулснаар 2019 оны байдлаар тэтгэврийн даатгалын санд 1,666.7 тэрбум төгрөг хуримтлуулсан бөгөөд энэ нь 2018 онтой харьцуулахад 527.5 тэрбум төгрөгөөр өссөн.

➤ **Тэтгэврийн параметрийг өөрчилсөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулав.**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэврийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлсэн, 20 жил 6 сараас дээш хугацаанд шимтгэл төлсөн бол 60/55 насандаа тэтгэвэр тогтоолгох зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулснаар дээрх нөхцөлөөр 2.8 мянган иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон.

➤ **Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан хуулийг хэрэгжүүлж байна.**

Малчдын өндөр насны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулснаар 9.4 мянган малчинд тэтгэвэр тогтоож, тэтгэвэрт 30.3 тэрбум төгрөг зарцуулав. Түүнчлэн Засгийн Газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”, “Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам”-ын дагуу 2019 онд 337 сум, 9 дүүрэгт зөвлөл байгуулагдан ажиллаж, 2.6 мянган малчин жил тодорхойлуулах хүсэлт гаргаснаас 2.2 мянган иргэний малчнаар ажилласан хугацааг тодорхойлж, эдгээр малчин өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөл бүрдсэн.

➤ **Тэтгэврийн хэмжээ 8 орчим хувиар нэмэгдэж, дундаж тэтгэврийн хэмжээ 378.9 мянган төгрөгт хүрсэн байна.**

Засгийн газрын 2019 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 26 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны

тэтгэврийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 24.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 310.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 270.0 мянган төгрөг болов. Тэтгэврийн нэмэгдэлд 119.5 тэрбум төгрөгийг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 379.8 мянган төгрөгт хүрэв.

➤ **Тэтгэврийн зээлийн хүүг дахин бууруулав.**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын Үндсэний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа.

2019 оны 01 дүгээр сараас 12 хүртэлх сарын хугацаатай тэтгэврийн 70 хувьтай тэнцэх хэмжээний зээлийн хүүг 2-8 пунктээр бууруулан, сарын 0.8 хувь, жилийн 10 хувь болгосон бөгөөд өнөөдрийн байдлаар 202111 тэтгэвэр авагч 217.1 тэрбум төгрөгийн зээлийг авч, тэтгэвэр авагчид 5.0 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна.

2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тэтгэвэр барьцаалсан зээлийн дээд хугацааг 24 сар болгон, 12 сар хүртлэх хугацаатай зээлийг жилийн 10 хувиар олгох ажлыг үргэлжлүүлэн, 13-24 сарын хугацаагаар олгох зээлийн хүүг 2.4 пунктээр бууруулан жилийн 15.6 хувь болгосноор 21124 тэтгэвэр авагч 103.2 тэрбум төгрөгийн зээлийг авч, тэтгэвэр авагчид 0.7 орчим тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна

➤ **Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 276.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлэв.**

Нийгмийн даатгалын санд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,603.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,879.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 117.2 хувиар биелүүлсэн. /Энэ дүнд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 605.5 тэрбум төгрөг ороогүй/.

➤ **Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулан, харилцах, хадгаламжийн хүүгээр сангийн орлогыг нэмэгдүүлэв.**

2019 онд Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны 10 банкинд байршуулж, 87.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон ба өмнөх оноос мөнгөн хөрөнгө 419.4 тэрбум, хүүгийн орлого 14.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

➤ **Нийгмийн даатгалын сангийн хуримтлагдсан өр, авлагыг барагдуулж байна.**

2019 оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 116.6 тэрбум төгрөг байснаас 59.8 тэрбум төгрөгийг бүрэн барагдууллаа. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, шимтгэлийн хувь хэмжээний нэмэгдэл, цалингийн сангийн өсөлт зэргээс хамаарч авлага шинээр 82.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 137.8 тэрбум төгрөг болсон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нь шимтгэлийн орлогын 7.7 хувийг эзэлж байна.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.

НД – ын байгууллагаас 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтыг чиглэл болгон 100 ажил үйлчилгээ, арга хэмжээг чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэхээр боловсруулжээ. Төлөвлөгөөний ажил, үйлчилгээ, арга хэмжээний биелэлт тус бүрт хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэхэд нийт хэрэгжилт 93,8 хувь байна. Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний 84 нь “үр дүнтэй”, 13 нь “тодорхой үр дүнд хүрсэн”, 3 нь “үнэлэх боломжгүй” гэж үнэлэгдсэн нь төлөвлөлт, түүний биелэлт, хэрэгжилтийн байдал байгууллагын төсөв, санхүү, дотоод үйл ажиллагаа хэвийн “тодорхой үр дүнд” хүрсэн байна.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь дунд хугацааны буюу 2019-2022 оны стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлснээр нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг үр дүнтэй хийж гүйцэтгэж байна.

Нийгмийн даатгалын санд 2019 оны жилийн эцсийн байдлаар шимтгэлийн орлого 1,603.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,879.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 117.2 хувиар биелүүлж, 655,0 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр. зардалд 2,062.2 тэрбум төгрөг зарцуулав.

Засгийн газрын шийдвэрээр тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулав. Засгийн газрын 2019 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 26 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 24000 төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 310.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 270.0 мянган төгрөг болов. Тэтгэврийн нэмэгдэлд 119.5 тэрбум төгрөгийг зарцуулсны дүнд дундаж тэтгэвэр 379.8 мянган төгрөгт хүрэв.

Цаашид энэ хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Нийгмийн даатгалын салбарын хууль эрхзүйн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын тухай багц хуулийн төслийг Засгийн газарт өргөн мэдүүлэх
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах
- 3 хүртэлх насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох зорилтын хүрээнд

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах

- Төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэн тооцдог болох зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлаар судлаачид, эрдэмтэдтэй хамтран ажиллах, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
- Хууль тогтоомжийн өөрчлөлт, хэрэглэгчийн хүсэлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд мэдээллийн технологи ашиглан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- Нийгмийн даатгалын тогтолцоонд Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид нийгмийн даатгалын үйлчилгээг шаардлагатай үедээ орон зай, цаг хугацаа үл хамааран хүртэх нөхцөл бүрдэнэ.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн
Ажлын алба